



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 10 өдөр

Дугаар А/АН

Булган сум

Оршуулгын газар олгох, үйл ажиллагаа эрхлэх,
зохион байгуулах үйл ажиллагаанд үнэлэлт,
дүгнэлт өгөх дэд ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.7 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргын 2025 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/10 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Оршуулгын газар олгох, үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулахтай холбогдсон хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг шалган танилцаж, үнэлэлт, дүгнэлт өгөх” дэд ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн дарга: О.Ундрах (Аймгийн Засаг даргын орлогч)

Гишүүд: Г.Давааням (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Салбарын хяналт, зохицуулалтын хэлтсийн дарга)
Б.Одхүү (Аймгийн Засаг даргын тамгын газрын
Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

А.Гантөмөр (Байгаль орчны газрын дарга)

П.Оюунцэцэг (Эрүүл мэндийн газрын дарга)

Б.Эрдэнэбилэг (Цагдаагийн газрын дарга,

хурандаа)

Ж.Ганболд (Улсын бүртгэлийн хэлтсийн дарга)

Ү.Бямбасүрэн (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын дарга)

Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга: Д.Буян-Өлзий (Тагнуулын хэлтсийн дарга)

2.Дэд ажлын хэсэг нь удирдамжийн дагуу хяналт шалгалтыг богино хугацаанд үр дүнтэй зохион байгуулж тайлан, мэдээллийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны дотор холбогдох газарт хүргүүлж ажиллахыг ажлын хэсгийн дарга (О.Ундрах)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325010997